

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 р сарын 16

Улаанбаатар хот

“Барилга” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ байгууллагын хурлын танхимд ТУЗ-ын нарийн бичгийн дарга хурлын ирц танилцуулсанаар 14.20 цагт 40092 хувьцаа эзэмшдэг гишүүд ирснээр 98,6 хувийн ирцтэй эхлэв. Хуралд хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ын хараат бус гишүүд оролцов.

ХЭХ-ыг ТУЗ-ын дарга Л.Шагдаррагчаа нээж хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ТУЗ-с гаргасан тогтоол, хурлын дэгийг танилцуулав. Дэгийг 100 хувь батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэргүүлэгчээр Г.Буд, Л.Шагдаррагчаа, Ш.Ариунбат нарыг томилов. Хуралд оролцогсод бүх тайлантай танилцсаны дараа асуулт хариулт, санал шүүмжлэлүүдийг хэлэлцэхээр тогтов.

Барилга ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа ТУЗ-ын тайланг уншиж танилцуулав. Тайланг хавсаргав.

Үүний дараа Барилга ХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат байгууллагын тайлан, оны үйл ажиллаганы үр дүн болон ирэх оны үйл ажиллаганы чиглэлийн талаархи тайлангаа уншиж танилцуулав. Тайланг хавсаргасан болно.

Ерөнхий нягтлан бодогч Э.Батсүх 2019 оны санхүүгийн тайлан, Эс Эм Аудит ХХК-ийн аудитын дүгнэлтийг болон аудитороос өгөгдсөн зааварчилгаа, зөвлөмжүүдийг уншиж танилцуулав. Зааварчилгаа зөвлөмжүүдийн дагуу өгөгдсөн хариулт, тайлбаруудыг дурьдсан бөгөөд санхүүгийн тайланг хавсаргав.

Бүх тайлангууд танилцуулагдсаны дараа асуулт хариулт руу шилжив:

Ш.Үнэнбат: Цаг үеийн байдалтай холбоотой үүссэн улсаас хэрэгжүүлж буй ААНОАТ, нийгмийн даатгалын шимтгэл, ХАОАТ-ын хөнгөлөлтүүдэд манай компани хэрхэн хамрагдах боломжтой вэ? ХЭХ-аар шийдүүлэх ямар нэг асуудал байгаа юу?

Э.Батсүх: ААНОАТ, Нийгмийн даатгалын шимтгэл, ХАОАТ-аас хөнгөлөгдөх боломжтой байгаа. Албан ёсны дүрэм, журам гарч ирэхээр түүний дагуу хөнгөлөлтүүдийг хөнгөлөх болно.

Ш.Эрдэнэбат: Хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль батлагдсан байгаа. Манай компанийн хувьд улсаас өгнө гэсэн 200.0 төгрөг бараг олгогдохооргүй байх шиг байна.

Ш.Үнэнбат: Дүрэм журам гарахаар түүний дагуу холбогдох хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг хийгээрэй.

Ш.Эрдэнэбат: Хувьцаа эзэмшигч Болд өөрийн хувьцаагаа зарах хүсэлтэй илэрхийлсэн байгаа. Бага хувьцаа эзэмшдэг хүмүүс мөн өөрсдийн хувьцаагаа зарах хүсэлт гаргах нь нээлттэй шүү. Бид үүнийг хүлээж авна. Энэ тал дээр өөрсдийн санаа оноог хэлээрэй.

Г.Буд: Мишй хувьд 5 ширхэг хувьцаа эзэмшдэг. Өгөх хүсэлтэй байна.

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Ш.Эрдэнэбат: Нийт хувьцаа эзэмшигчдэд хандаж хэлэх үг байна. Цаашид Хувьцаат Компаниар биш ХХК болговол ямар вэ? Та нарт энэ тал дээр санаа оноонуудаа хэлнэ үү?

Г.Буд: ХХК байх нь үйл ажиллагаа явуулахад хамаагүй хялбар, чирэгдэл багатай байдаг. Тайлан балансаа өгөөд, татвар шимтгэлээ төлөөд болоо. Би ХХК болговол дэмжинэ.

С.Сүхбаатар: Ер нь ирээдүйгээ харахын бол Хувьцаат компани байх нь зүйтэй.

Л.Шагдаррагчаа: Их зүйтэй саналууд хэлж байна. Цаашид анхааръя.

Саналуудын дараа гарах тогтоолын төслүүдэд санал хурааж тарааж өгсөн саналын хуудсуудыг хурааж авав. Тогтоол 3, 4, 5-ийг 100 %-ийн санал нэгтэй дэмжив. Тогтоол 6 дээр тусгасан гэрээт аудитын хөлсийг 8 сая төгрөгөөр тооцохоор тогтов. Тогтоол 6-г 100 %-ийн санал нэгтэй батлав.

Өөр санал гарсангүй, хурал 16.30 цагт дуусав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТҮЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.АРИУНТУЯА